



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Түдэвтэй сум дахь сум дундын ойн ангийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2025/213/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: b.dagvaa1000@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Уластай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@zaudit.gov.mn

2024.08.21 № 824

танай

-ны №

ТҮДЭВТЭЙ СУМ ДАХЬ
СУМ ДУНДЫН ОЙН АНГИЙН
ДАРГА Э.ДАРАМСЭНГЭ-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түдэвтэй сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Түдэвтэй сум дахь Сум дундын ойн анги нь дарга, инженер, техникч гэсэн үндсэн 3 орон тоотой, 139,203.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 15 сумын 326,421 га ойн сан хариуцан, ойн нөөц баялгийг хамгаалах зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нэгдсэн бодлого, аймгийн болон сумдын ойн менежментийн төлөвлөгөө, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газар, аймгийн Байгаль орчны газраас өгсөн чиглэл, бодлогыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Аудитын гол асуудал

Түдэвтэй сум дахь Сум дундын ойн ангийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар 13,498.0 мянган төгрөгийн газрыг үндсэн хөрөнгөд тусгаагүй, ойн ерөнхий инженерт байгууллагын орон тоонд батлагдаагүй нярвын албан тушаалыг хавсран гүйцэтгүүлж, үндсэн цалингаас 20 хувиар нэмэгдэл олгосон, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Дарамсэнгэд ажил хавсран гүйцэтгэсэн 40 хувийн цалинг механик инженерийн үндсэн цалингаас тооцож олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Ойн анги нь татварын бус орлогоор 100,405.9 мянган төгрөг, өөрийн орлогоор

D/disk/Албан бичиг/Дүгнэлт

81250332

3,500.0 мянган төгрөг төвлөрүүлж, аймгийн ИТХ-ын шийдвэрээр 6,889.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг акталж, бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д. БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

Код	Үзүүдэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	\$7944011.00	\$13928211.00
33	АВЛАГА	\$10000.00	\$10000.00
33500	Бусад авлага	\$10000.00	\$10000.00
33510	Байгууллагаас авах авлага	\$10000.00	\$10000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	\$7934011.00	\$13918211.00
35400	Хангамжийн материал	\$7934011.00	\$13918211.00
35410	Бичиг хэргийн материал		\$220500.00
35420	Аж ахуйн материал	\$7518711.00	\$8587711.00
35440	Түлш, шатах тослох материал	\$305300.00	
35470	Бусад хангамжийн материал	\$110000.00	\$5110000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	\$50884019.89	\$80717917.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	\$50884019.89	\$80717917.17
39100	Газар		\$1134000.00
39200	Биет хөрөнгө	\$50884019.89	\$66085917.17
39203	Авто-тээврийн хэрэгсэл	\$68603535.00	\$66913535.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Гээврийн хэрэгсэл	-\$32437221.98	-\$37191318.36
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	\$17244550.40	\$36065034.40
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	-\$17244550.40	-\$12122499.31
39214	Бусад үндсэн хөрөнгө	\$21956754.00	\$21956754.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	-\$7239047.13	-\$9535588.56
39300	Биет бус хөрөнгө		\$13498000.00
39301	Програм хангамж	\$770000.00	\$770000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	-\$770000.00	-\$770000.00
39303	Бусад биет бус хөрөнгө		\$13498000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	\$58828030.89	\$94646128.17
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	\$58828030.89	\$94646128.17
51	Засгийн газрын хувь оролцоо	\$58828030.89	\$94646128.17
51200	Хуримтлагдсан үр дүн	\$58828030.89	\$94646128.17
51210	Өмнөх үеийн үр дүн	\$71122168.90	\$58828030.89
51220	Тайланг үеийн үр дүн	-\$12294138.01	\$35818097.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	\$58828030.89	\$94646128.17

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан
 2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	\$67745816.97	\$160713062.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	\$1439810.00	\$54996794.00
1200	Нийтлэг татварын бус орлого	\$1439810.00	\$54996794.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	\$1439810.00	\$11345000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	\$1439810.00	\$11345000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		\$38651794.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал		\$5000000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	\$66306006.97	\$105716268.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	\$9350000.00	\$10215000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	\$9350000.00	\$10215000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	\$57942500.00	\$96755900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	\$57942500.00	\$96755900.00
1330	Төсвийн захирагчдаас	-\$986493.03	-\$1254631.61
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-\$986493.03	-\$1254631.61
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	\$80039954.98	\$124894965.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ	\$80039954.98	\$124894965.11
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	\$80039954.98	\$124894965.11
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	\$42030550.97	\$78330981.39
210101	Үндсэн цалин	\$35529883.62	\$54135600.00
210102	Нэмэгдэл	\$3367929.64	\$17028287.70
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	\$1563153.99	
210104	Урамшуулал	\$1569583.72	\$7167093.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	\$5662500.00	\$9929200.00
210201	Тэтгэврийн даатгал	\$3850500.00	\$6751800.00
210202	Тэтгэмжийн даатгал	\$453000.00	\$794300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	\$362400.00	\$635500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	\$90600.00	\$158900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	\$906000.00	\$1588700.00
2104	Хангамж, бараа материалын зардал	\$3107000.00	\$11201000.00
210401	Бичиг хэрэг	\$448600.00	\$357100.00
210402	Тээвэр, шатахуун	\$1527000.00	\$10442900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	\$350400.00	\$401000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	\$120000.00	
210408	Бараа материал актласны зардал	\$661000.00	
2105	Нормативт зардал	\$29000.00	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	\$29000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	\$415000.00	\$248600.00

210604	Урсгал засвар	\$415000.00	\$248600.00
2107	Томилолт, зочны зардал	\$1060900.00	\$3061200.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он
210702	Дотоод албан томилолт	\$1060900.00	\$3061200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	\$251950.00	\$274800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	\$150000.00	\$150000.00
210803	Даатгалын үйлчилгээ	\$50500.00	\$50500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	\$25500.00	\$27300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	\$25950.00	\$47000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	\$27483054.01	\$21849183.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	\$15494616.00	\$13031287.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	\$11988438.01	\$8817896.72
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	-\$12294138.01	\$35818097.28
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	-\$12294138.01	\$35818097.28

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан
2024 оны 12 дугаар сарын 31 /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайланг он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	\$67745816.97	\$117061268.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	\$1439810.00	\$11345000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	\$1439810.00	\$11345000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	\$1439810.00	\$11345000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	\$1439810.00	\$11345000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	\$66306006.97	\$105716268.39
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	\$9350000.00	\$10215000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	\$9350000.00	\$10215000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	\$57942500.00	\$96755900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	\$57942500.00	\$96755900.00
1330	Төсвийн захирагчдаас	-\$986493.03	-\$1254631.61
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-\$986493.03	-\$1254631.61
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	\$67745816.97	\$117061268.39
21	УРСГАЛ ЗАРДАЛ	\$67745816.97	\$117061268.39
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	\$67745816.97	\$117061268.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	\$42030550.97	\$78330981.39
210101	Үндсэн цалин	\$35529883.62	\$54135600.00
210102	Нэмэгдэл	\$3367929.64	\$17028287.70
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	\$1563153.99	\$7167093.69
210104	Урамшуулал	\$1569583.72	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	\$5662500.00	\$9929200.00

210201	Тэтгэврийн даатгал	\$3850500.00	\$6751800.00
210202	Тэтгэмжийн даатгал	\$453000.00	\$794300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	\$362400.00	\$635500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	\$90600.00	\$158900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	\$906000.00	\$1588700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	\$110656.00	
210302	Түлш, халаалт	\$110656.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	\$2481300.00	\$7169400.00
210401	Бичиг хэрэг	\$247600.00	\$247600.00
210402	Тээвэр, шатахуун	\$1832300.00	\$6520800.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	\$401400.00	\$401000.00
2105	Нормативт зардал	\$139000.00	\$139000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	\$139000.00	\$139000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	\$248600.00	\$248600.00
210604	Урсгал засвар	\$248600.00	\$248600.00
2107	Томилголт, зочны зардал	\$1060900.00	\$3061200.00
210702	Дотоод албан томилголт	\$1060900.00	\$3061200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	\$273000.00	\$274800.00
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	\$150000.00	\$150000.00
210803	Даатгалын үйлчилгээ	\$50500.00	\$50500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	\$25500.00	\$27300.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	\$47000.00	\$47000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	\$15739310.00	\$17908087.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	\$15739310.00	\$17908087.00
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2024 оны 12 -р сарын 31 өдөр

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			\$71122168.90		\$71122168.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			\$71122168.90		\$71122168.90
9	Тайлант үеийн үр дүн			\$12294138.01		-\$12294138.01
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			\$58828030.89		\$58828030.89

12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл			\$58828030.89		\$58828030.89
19	Тайлант үеийн үр дүн			\$35818097.28		\$35818097.28
Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
20	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			\$94646128.17		\$94646128.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл				
11100	Үүнээс: Банкнй дахь харилцах дансны үлдэгдэл				
11200	Кассын оны эхний үлдэгдэл				
70106	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага				
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал				
71403	Ойжуулалт	\$100255900.00	\$100405900.00	-\$150000.00	100.15
12	Татварын бус орлого	\$100255900.00	\$96755900.00	\$3500000.00	96.51
12000	Нийтлэг татварын бус орлого	\$3500000.00		\$3500000.00	
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	\$3500000.00		\$3500000.00	
12200	Тусламжийн орлого	\$96755900.00	\$96755900.00		100.00
122005	Төсвөөс санхүүжих	\$96755900.00	\$96755900.00		100.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	\$100255900.00	\$100405900.00	-\$150000.00	100.15
21	УРСГАЛ ЗАРДАЛ	\$100255900.00	\$99153181.39	\$1102718.61	98.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	\$100255900.00	\$99153181.39	\$1102718.61	98.90
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	\$79433100.00	\$78330981.39	\$1102118.61	98.61
210101	Үндсэн цалин	\$54135600.00	\$54135600.00		100.00
210102	Нэмэгдэл		\$17028287.70	-\$17028287.70	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	\$25297500.00	\$7167093.69	\$18130406.31	28.33
210104	Урамшуулал				
2102	Ажил олгогчоос нийгмийн даятгалд төлөх шийтгэл	\$9929200.00	\$9929200.00		100.00
210201	Тэтгэврийн даатгал	\$6751800.00	\$6751800.00		100.00
210202	Тэтгэмжийн даатгал	\$794300.00	\$794300.00		100.00
210203	ҮОМШО-ний даатгал	\$635500.00	\$635500.00		100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	\$158900.00	\$158900.00		100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	\$1588700.00	\$1588700.00		100.00

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
210301	Гэрэл, цахилгаан				
210302	Түлш, халаалт				
2104	Хангамж, бараа материалын зардал	\$7170000.00	\$7169400.00	\$600.00	99.99
210401	Бичиг хэрэг	\$247600.00	\$247600.00		100.00
210402	Тээвэр, шатахуун	\$6521000.00	\$6520800.00	\$200.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	\$401400.00	\$401000.00	\$400.00	99.90
2105	Нормативт зардал	\$139000.00	\$139000.00		100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	\$139000.00	\$139000.00		100.00
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	
				Дүнгээр	%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	\$248600.00	\$248600.00		100.00
210604	Урсгал засвар	\$248600.00	\$248600.00		100.00
2107	Томилголт, зочны зардал	\$3061200.00	\$3061200.00		100.00
210702	Дотоод албан томилолт	\$3061200.00	\$3061200.00		100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	\$274800.00	\$274800.00		100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	\$150000.00	\$150000.00		100.00
210803	Даатгалын үйлчилгээ	\$50500.00	\$50500.00		100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	\$27300.00	\$27300.00		100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	\$47000.00	\$47000.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал				
210901	Бараа үйлчилгээний бусад зардал				
26	Төвлөрүүлэх шилжүүлэг		\$1252718.61	-\$1252718.61	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг		\$1252718.61	-\$1252718.61	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		\$3650000.00	-\$3650000.00	
35	Нэмэлт санхүүжилтийн орлого		\$3650000.00	-\$3650000.00	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		\$3650000.00	-\$3650000.00	
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
12100	Үүээс: Банкни дахь харилцах дансны үлдэгдэл				
12200	Кассын дансны эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайл

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
-----	----------	-----------

I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	\$17908087.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	\$17908087.00
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	\$17908087.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	\$17908087.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	\$17908087.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	\$17908087.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	\$7695000.00
1200	Нийтлэг татварын бус орлого	\$7695000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	\$7695000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	\$7695000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТНИЙ ОРЛОГО	\$10213087.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	\$10215000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	\$10215000.00
1330	Төсвийн захирагчдаас	-\$1913.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	-\$1913.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эсвэл үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Түдэвтэй суман дахь сум дундын ойн анги:

Ойн тухай хууль тогтоомжийг хариуцсан сумын нутаг дэвсгэрт хэрэгжүүлэх, ойн сан хамгаалах ажлыг удирдан зохион байгуулах, ойн хортон, түймэртэй тэмцэх урьдчилан сэргийлэх, ойн мэдээллийн санг бүрдүүлэх, ойн баялагийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, тод бут тарих, арчлах, ургуулах талаар сургалт сурталчилгаа зохион байгуулах мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ойжуулалтын ажлыг гүйцэтгэх, ой хамгаалах иргэдийн нөхөрлөлийн ажилд дэмжлэг үзүүлэхэд байгууллагын зорилго оршино.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Төрийн албаны тухай хууль
2. Ойн тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дот оод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түдэвтэй суман дахь сум дундын ойн анги: 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Түдэвтэй суман дахь сум дундын ойн анги: 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 35,818.0 мянгантөгрөгөөр буюу 60.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	10,000	10,000	
Бараа материал	7,934.01	13,918.1	5,984.2
Үндсэн хөрөнгө	50884.02	80,717.9	29,833.88
Нийт хөрөнгө	58,828.03	94,646.1	35,818.07
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	58,828.03	94,646.1	35,818.07
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	58,828.03	94,646.1	35,818.07

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд: Үнсэн хөрөнгө: Завхан Аймагийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар HP принтер-1ш, Зөөврийн компьютер-1ш 4,635,534 төгрөгийн машин тоног төхөөрөмж,

Монгол улсын ногоон сэргэлтийн бодлогын хүрээнд “ойн түймэртэй тэмцэх чадавхыг сайжруулах” төслийн хүрээнд, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Ойн газраас нийлүүлж буй **19,384.26** төгрөгийн машин тоног төхөөрөмж,ОНХС-ийн хөрөнгө

оруулалтаар хийгдсэн **5,000,000** төгрөгийн үнэ бүхий мод үржүүлгийн өргөтгөлийн тоног төхөөрөмжийг бүртгэлд тусгаснаар хөрөнгө өссөн байна.

2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн “Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” 345 дугаар тогтоолоор машин тоног төхөөрөмж **5,199.3** мянган төгрөг, **1,690.0** мянган төгрөгийн мотоцикл оруулан актлан данснаас хасах төрийн өмийн бодлого зохицуулалтын газарт тайлан хүргүүлэн ажилласан.

Бараа материал: оны эхэнд 79,194.9 мянган төгрөг байсан бөгөөд төсвийн хөрөнгөөр 88,932.3 мянган төгрөгийн бараа материал, үнэ төлбөргүйгээр 75,604.8 мянган төгрөгийн бараа шилжүүлэн авч 130,109.6 мянган төгрөгийн бараа материалыг зарлага бологон 113,622.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй үлдэж өмнөх оноос мал амьтадын үлдэгдэл өссөн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ **94,646.1** мянган төгрөг нь тайлант онд өөрчлөлт ороогүй болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 182,255,1 мянган төгрөг, нийт зарлагыг 182,255,1 мянган төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн арга хэмжээг санхүүжүүлэхээр 100,255,9 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 100,255,9 мянган төгрөг буюу 100 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөргүй хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
	ХХААХҮЯам				
71403	Үндсэн үйл ажиллагааны зардал	100,255,9	100,405,9	150,0	100.15%
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	100,255,9	100,405,9	150,0	100.15%
НИЙТ		100,255,9	100,405,9	150,0	100.15%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр 17,908.0 мянган төгрөг зарцуулж тоног төхөөрмөж бэлтгэсэн байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд гэрээ байгуулах/Эс эс софт/	Байгууллагын гадна,дотно камержуулалт	3,020.0	3,020,0
2	Шууд гэрээ байгуулах/Пи си молл/	Ухаалаг компьютер,принтер	15,647.6	15,647.6
3	Шууд гэрээ байгуулах/Жойфүл фамили ХХК/	Ус цэвэршүүлэгч	1,500.0	1,500.0
	Дүн		20,167.6	20,167.6

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс,хөдөө аж ахуйн газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит” ХХК-ийн ахлах аудитор Б.Дагвасүрэн хийж анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хүнс,хөдөө аж ахуйн газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын 160,713.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,214.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,571.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, санхүүгийн үр дүнгийн тайлан өөрчлөгдсөн тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн, үр дүнгийн тайлангийн нийт орлогын 160,713.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 3,214.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 2,571.5 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудит хийгдээгүй

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөвлөмж, акт, албан шаардлага өгөгдөөгүй

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,099.3 мянган төгрөгийн алдаа илэрч 20,387.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 291.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоогдож, 421.0 мянган төгрөгийн зөвлөмж өгөгдөсөн.

Залруулсан алдаа:

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодруулагад акталсан 6,889.3 мянгантөгрөгийн машин тоног төхөөрөмжийг хасалт хийгээгүй, 13,498.0 мянган төгрөгийн газрыг тусгаагүй алдаа нь "Иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн байдал: залруулж тайлан гаргасан

5.1 Төлбөрийн акт

Тус байгууллагад няравын орон тоо батлагдаагүй байхад ойн ерөнхий инженер нь няравын албан тушаалыг хавсран гүйцэтгэж өөрийн үндсэн цалингаас 20% авсан зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох;" Төсвийн тухай хуулийн 41.2.2 Батлагдсан төсвийн хүрээнд зардал гаргах" гэсэн заалдтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоох

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Дарамсэнгэ нь ажил хавсран гүйцэтгэсэн 40%- ийн цалинг өөрийн үндсэн цалингаас авсан зөрчил илэрсэн

Энэ нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын "2.2. Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно. 2.3. Төрийн албаны тухай хуулийн 43.3.4-т заасан үндэслэлээр төрийн албан хаагчийн нөөцөд бүртгэгдсэн иргэнийг сонгон авч түр орлон гүйцэтгүүлсэн бол тухайн албан тушаалын цалинг түүнд олгоно.2.4. Төрийн албаны тухай хуулийн 3.1.4-т тодорхойлсон сул орон тооны албан үүргийг түр орлон гүйцэтгэх тохиолдолд тухайн албан тушаалын үндсэн цалингийн зөрүүг түр орлон гүйцэтгэсэн хугацаагаар тооцож олгоно. Албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн үндсэн цалин, сул орон тооны албан тушаалын үндсэн цалинтай адил буюу түүнээс бага байх тохиолдолд энэ журмын 2.2-т заасныг баримтална. гэсэн заалтууд, "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн байдал:



Иймд уг зөрчлийг арилгуулахаар доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын "2.2. Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно " гэсэн заалтыг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн илэрч 712.0 мянган төгрөгийн алдаа нь бидний тогтоосон материаллаг түвшингээс доогуур байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭЛТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Зөвлөмж	
									Залруулсан	Залруу-лаагүй
Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тодрууллагад агагласан 6,889.3 мянгантөгрөгийн машин тоног төхөөрөмжийг хасалт хийгээгүй, 13,498.0 мянган төгрөгийн газрыг тусгаагүй алдааг залруулсан	2	20,387,310					2	20,387,310		
Дүн	1	20,387,310		0		0	2	20,387,310		0

Мянаган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Мянаган төгрөгөөр/
Үнээс

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Наравын орон тоо батлагдаагүй байхад ойн ерөнхий инженер нь наравын албан тушаалыг хавсран гүйцэтгэж өөрийн үндсэн цалингаас 20% авсан зөрчил нь	1	291041	1	291041								
Байгууллагын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Дарамсэнтэ нь ажил хавсран гүйцэтгэсэн 40%-ийн цалинг өөрийн үндсэн цалингаас авсан зөрчил	1	421000					1	421000				
Дүн	2	712041	1	291041			1	421000				



АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ОЮУНСУВД
Х.БОЛДБААТАР

Д.БАТ-УНДРАА

Огноо: 2025-02-15

БОЛОВСРУУЛСАН:

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК

АХЛАХ АУДИТОР

Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-15

